

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ, ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН ТҮҮХТ 85 ЖИЛИЙН ОЙД

БАЙЛДААНЫ БОЛОН ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНТ ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛЬ



Хилийн албаны сургууль нь байгуулагдсан цагаасаа хойш улс эх орны аюулгүй байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалах хууль ёсыг сахиулах хэрэгцээ шаардлагад нийцсэн дээд, тусгай дунд боловсролтой 7000 гаруй хилчин, офицер, эрх зүйчдийг бэлтгэн гаргажээ.

Монгол Улсын “Хилийн тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлийн 34.1-д “Хил хамгаалах байгууллагын үндсэн хүч хэрэгсэл нь хилийн цэрэг байх бөгөөд үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай хилийн цэргийн штаб, анги салбар, зэвсэглэл, техник, ар тал хангалт, эмнэлэг, соёл урлаг, спорт, боловсрол, эрдэм шинжилгээний болон бусад нэгжтэй байна” гэсэн заалтыг хэрэгжүүлэн, Монгол Улсын Засгийн Газраас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулж, улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдал, улсын хил хамгаалалтыг бэхжүүлэхэд цэргийн хэрэг, улс төр, хууль, эрх зүйн тусгай мэргэжлийн боловсролтой олон мянган офицер ахлагч нарыг бэлтгэж өгсөн түүхтэй.

БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчдийн 1984 онд гаргасан зарлигаар эх орныхоо аюулгүй байдал, дархан хилийн хамгаалалтад оруулсан тус сургуулийн хувь нэмрийг үнэлж “Байлдааны гавьяаны одон”-гоор шагнасан бол Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2006 оны 6 дугаар сарын 14-ний 139 тоот тогтоолоор тус сургуулийн төгсөгч МУ-ын баатар С.Лхагвадоржийн нэрэмжит болгосон юм.

Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 229 тоот тогтоолоор хуучнаар Хилийн цэргийн дээд сургууль нь Цагдаагийн академитай нэгдэн Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургууль болон өргөжиж улмаар Хууль зүйн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн 141 тоот тушаалаар Хууль сахиулахын их сургуулийн Хилийн сургууль нэрээр явж ирсэн бол өнөөдөр тус сургууль нь Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн а/126 дугаар тушаалаар

Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургууль болж, Их сургуулийг хөгжүүлэх цогц бодлогын хүрээнд багш нарыг эрдэмжүүлж, сургалтын чанарыг дээшлүүлэн, Хил хамгаалах байгууллагын сургалтын нэгдсэн тогтолцоог бий болгох,

сургалтын гадаад, дотоод орчны таатай нөхцлийг бүрдүүлэх, бакалаврын болон мэргэжлийн боловсролын түвшинд хөрвөх боломжтой шинэ мэргэжлүүдээр сургалтын агуулга хэлбэрийг өргөжүүлэх чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Батлагдсан бүтэц, зохион байгуулалтын дагуу тус сургууль нь өнөөдрийн байдлаар Хилийн албаны сургуулийн захирлын ажлын алба, мэргэжлийн 7 тэнхимтэйгээр сургалтыг

зохион байгуулж байна. Багшлах бүрэлдэхүүний 2 буюу 9.3% нь доктор, 6 буюу 18,9% нь докторант, 71,8% нь магистр зэрэгтэй байна.

ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын үндэсний аюулгүй байдал язгуур ашиг сонирхлыг хилийн орон зайд үнэнч шударгаар хамгаалдаг, эх оронч үндэсний үзэлтэй, өв тэгш хүмүүжилтэй, хилийн албаны болон цэргийн хэргийн өндөр боловсрол мэргэжил бүхий офицер, ахлагч нарыг бэлтгэдэг хил хамгаалах байгууллагын сургалт, судалгаа, хөгжлийн төв болоход оршино.

ЗОРИЛТ

Хилийн албаны сургууль 2019 онд “Сургалтын чанарыг сайжруулах ажлын хүрээнд сонсогчдын сурах сургалтын орчин бүрдүүлж, бие бүрэлдэхүүний албаны чадавхийг нэмэгдүүлнэ.” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

АЛСЫН ХАРАА

Хилийн албаны аюулгүй байдлыг хангах ажлын Шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэлийн нэгдсэн инновацийн үр ашигтай тогтолцоог бий болгож, хөгжүүлэн Хил судлалын шинжлэх ухааны чиглэлд тэргүүлэх байр суурьтай, зөвлөх эрхтэй, сургалт судалгаа, оюуны төв байхад чиглэнэ.

ТҮҮХЭН ЗАМНАЛ

Хилийн сургууль нь 1933 онд “Хязгаарын ба гүйцэтгэх ажилтны курс” нэртэйгээр байгуулагдсан тусгай мэргэжлийн боловсрол олгох манай улсын ууган сургуулиудын нэг бөгөөд 1951 онд татан буугдаж 1974 онд дахин байгуулагдсан.

Тус сургууль нь:

- 1934 Дотоод Явдлын Яамны Төв Сургууль
- 1940-1950 онд Хязгаарын ба Дотоодын цэргийн төв сургууль
- 1974-1982 онд НАХЯ-ны Цэргийн тусгай дунд сургууль
- 1982-1990 оноос НАХЯ-ны Цэргийн дээд сургууль
- 1990-1994 онд Цагдаагийн Дээд сургуулийн Хилийн албаны тэнхим
- 1994-1997 онд Цэргийн их сургуулийн Хилийн факультет
- 1997-1999 онд Цэргийн их

сургуулийн харьяа Хилийн цэргийн сургууль

- 1999 онд Батлан хамгаалахын их сургуулийн Хилийн цэргийн сургууль
- 2001 онд Хилийн Цэргийн Дээд сургууль
- 2011 онд ДХИС-ийн Хилийн Албаны сургууль
- 2012 онд ХСИС-ийн Хилийн сургууль
- 2019 оноос ДХИС-ийн Хилийн албаны сургууль нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

БИДНИЙ БАХАРХАЛ

Манай сургуулийн сонсогч Монгол улсын баатар С.Лхагвадорж, Хилийн цэрэгт алба хааж эх орныхоо бүтээн байгуулалтад ялгуусан амжилт гаргаж, ард олондоо алдаршсан дэслэгч генерал Ж.Жамъян, гавьяат хуульч Б.Цэдэн-Иш, дархан аварга Б.Бат-Эрдэнэ нарын хөдөлмөрийн баатрууд, ардын жүжигчин С.Гэндэн, урлагийн гавьяат зүтгэлтэн Ш.Эрдэнэбат, гавьяат нисэгч Т.Сугар, гавьяат дасгалжуулагч Д.Дашжамц, шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн Ш.Арвай нарын хорь орчим гавьяат цолтнууд, Л.Намсрай, Б.Цэдэн-Иш, Ч.Сангишарав, Ш.Арвай, С.Гүржав, Я.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн, М.Лхачинжав Т.Хүрэлбаатар, Ж.Бямбасүрэн нарын арав гаруй генералууд, Ш.Арвай, Т.Лхагвасүрэн, Б.Цэдэн-Иш, Ц.Энхжаргал, А.Осор, Ц.Пүрэв, А.Муратхан, Ч.Жазаг, Г.Дагважамц, П.Баттогтох, С.Гүржав, П.Даш, Б.Бат-Эрдэнэ, Ц.Ганболд, Д.Нямдорж, Б.Лхагва, Н.Наранжамц, И.Сэржхүү, Ж.Өвгөнбүргэд, В.Жавхланцогт, Ц.Батбаяр,

Д.Дашдаваа, Д.Чойбаатар, Ё.Хадхүү нарын 40 гаруй эрдэмтэн докторууд, Д.Дорж, М.Банзрагч, Д.Жамъян, Ц.Уламбаяр, Ш.Доржбал нарын хорь орчим зохиолч, сэтгүүлчид төрснөөр бид бахархаж явдаг.





Тус сургуулийг улс орны аюулгүй байдал, улсын хилийг хамгаалах их үйлс, бүтээн байгуулалтад оруулсан хувь нэмэр, эх оронч баатрууд, цэргийн олон шилдэг дарга нар, улс ардын аж ахуйн болон соёл урлаг, шинжлэх ухаан, спортын нэрт зүтгэлтнүүдийг төрүүлсэн гавьяаг үнэлэн Сайд нарын зөвлөлийн 1949 оны зарлигаар байлдааны туг олгож, 1979 онд МХЗЭ-ийн Төв хорооны “Цэргийн алдар” алтан медаль, 1980 онд НАХЯ-ны “Хүндэт чекист” тэмдэг, 1984 онд “Байлдааны гавьяаны одон”-гоор тус тус шагнасан байна.

ТОМООХОН ҮЙЛ ЯВДАЛ, БҮТЭЭЛЧ АЖЛУУД




Хил хамгаалах ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар тохижуулсан Хилийн сургуулийн лаборатори, танхимуудын нээлтийн үйл ажиллагааг 2017 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулсан. Уг үйл ажиллагаанд Хууль сахиулахын их сургуулийн захирал, цагдаагийн хурандаа Ө.Энхтөр, Хил хамгаалах ерөнхий газрын дарга бөгөөд Хилийн цэргийн командлагч, хошууч генерал Ц.Сэргэлэн болон захирлын зөвлөл, даргын зөвлөлийн гишүүд оролцсон. Мөн Улаанбаатар хүрээний Хилийн 10 ангийн захирагч нар урилгаар оролцож, Их сургуулийн төв байр, Хилийн сургуулийн үйл ажиллагаатай /2017.11.17 өдөр/ танилцсан.



Сургалтын үйл ажиллагаанд ашиглах “Хийн буудлага”-ын лаборатори танхимыг тохижуулах ажлыг хийж гүйцэтгэн сургалтад ашиглаж эхэлсэн./2018.02.15 өдөр/




Хил хамгаалах ерөнхий газар, Хууль сахиулахын их сургууль хамтран ажиллах “Санамж бичиг” хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, хамтран ажиллах санамж бичгийг 2018 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан.





Хил хамгаалах ерөнхий газраас Хилийн 0345 дугаар тусгай ангид шилжүүлсэн зэвсгийг 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдөр хүлээн авсан.



Хууль сахиулахын их сургуулийн “Марш-тусгай бэлтгэлийн аварга” шалгаруулах тэмцээнд тус сургуулийн албан хаагчдын баг тамирчид тэмцээнд амжилттай бэлтгэн оролцож, албан хаагчдын баг тэргүүн, сонсогч бүрэлдэхүүний дэд байрт шалгарч, багийн дүнгээр тэргүүлсэн. /2018 оны 4 дүгээр сар/



Төгсөх дамжааны дамжааны сонсогчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор “Их сорилго”-тактикийн сургуулийг жил бүрийн хавар Гүнжийн хоолой дахь хээрийн сургалт бэлтгэлийн төвд уламжлал болгон зохион байгуулдаг болсон.




Тус сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн бүрэлдэхүүн санаачилан, “Буудлагын иж бүрэн стандарт талбай” байгуулах ажлыг 2018 оны 06 дугаар сарын 08-наас 15-ны өдрүүдэд сонсогчдын хамтаар гардан хийж гүйцэтгэсэн.




Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар, ахмад С.Лхагвадоржийн хөшөөг Хилийн албаны сургуулийн үүдэнд суурилуулж, нээлтийн үйл ажиллагааг ёслол төгөлдөр зохион байгуулж, С.Лхагвадоржийн мэндэлсэний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн.




Монгол Улсын Их хурлын Хууль зүйн байнгын хороо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль сахиулахын их сургууль, Хил хамгаалах ерөнхий газар, Холбооны Бүгд найрамдах Герман улсын Ханнс-Зайделийн сан хамтран зохион байгуулсан “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах ажлыг хамтран гүйцэтгэсэн.



Улсын Их Хурлын дэд дарга Я.Санжмятавын санаачлагаар Завхан аймгийн ерөнхий боловсролын 11,12 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулсан “Бид Чингисийн үр сад, зөв тэмүүлэл, эх оронч манлайлал” сэдэвт цэрэг эх оронч сурагч хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааг тус сургуулийн багш, сонсогчид амжилттай зохион байгуулж, Монгол Улсын ерөнхийлөгчийн тамгийн газар болон Их сургуулийн удирдлагад танилцуулсан. /2018.09.04-21/



Их сургуулиас зохион байгуулсан “Сонсогчийн жавхаа-2018” уралдаанд хилчин сонсогчид оролцож, Хууль сахиулахын их сургуулийн “Тэргүүний дамжаа”-аар 433 дугаар дамжаа, “Тэргүүний бага дарга”-аар бага дарга, түрүүч н.Батбаатар нар тус тус шалгарсан.



Дэлхийн болон олон улс, улсын чанартай тэмцээн, уралдаанд тус сургуулийн бие бүрэлдэхүүн амжилттай оролцож, тэргүүн байруудад шалгарсан.